



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/021/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Ахлах аудитор Ц.Саранчимэг
Утас: 70273204 Цахим хаяг: Saranchimegtst@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.4.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага	11
3.5.3 Урьдчилгаа	11
3.5.4 Бараа материал	11
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө	12
3.5.6 Үндсэн хөрөнгө	12
3.5.7 Өр төлбөр	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.1 Төлбөрийн акт.....	21
5.2 Албан шаардлага.....	21
5.3 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БНСБС	Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим сайт: www.audit.mn

2025.03.24 № 01/2025

танай _____ -ны № _____ -г

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.ЭНХСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Баяндэлгэр сумын ИТХ-ын тогтоолоор татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 584,537.8 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 493,234.9 мянган төгрөг, нийт дүнгээр 91,302.9 мянган төгрөгөөр тасарсан зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 23 дугаар зүйлийн 23.1-д "Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ", 23.8-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасан заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, 4 орон нутгийн тусгай сан, 1 төрийн сангийн нэгж нийт 11 тайлан нэгтгэгдсэн байна. Төсвийн төвлөрүүлэн

412506490

захирагч нь зөвхөн гүйцэтгэл үр, дүнгээр санхүүжих 4 байгууллагын орон нутгаас баталсан төсвийн хүрээнд тайлагнаж нэгтгэлд оруулсан байна.

Тайлант онд Баяндэлгэр сумын хэмжээнд дараах ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд: Иргэдэд хүнд сурталгүй, шуурхай үйлчилгээг хүргэх зорилгоор "Нэг цэгийн үйлчилгээ"-г нэвтрүүлэн иргэдийн төрийн үйлчилгээг авахад хялбар, хурдан болгосон, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн айл өрх бүрийн гадна нарны эрчим хүчээр цэнэглэдэг гэрэлтүүлэг суурилуулж, иргэдийн аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг сайжруулсан. Ерөнхий боловсролын сургууль болон хүүхдийн цэцэрлэгийн дотор сантехникийн их засвар хийж, багш, хүүхдүүдийн аюулгүй, дулаан орчинд ажиллах, суралцах нөхцөлийг бүрдүүлсэн. Галуут, Байдлаг багт үүссэн гуу жалгаас болж иргэд зорчих боломжгүй болсон гол усанд шинэ гүүр барьж, иргэдийн тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Баяндэлгэр сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 535,160.1 мянган төгрөгөөр баталснаас 2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 26 тоот тогтоолоор 584,537.8 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 493,234.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж 91,302.9 мянган төгрөгөөр буюу 15,6 %-аар тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг дарга болон Сумын засаг дарга нарын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ нь 2024 онд нийт 11 зорилт, 105 хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ дэвшүүлэн ажилласнаас 44 зорилтын хэрэгжилт үр дүнтэй, 12 зорилт тодорхой үр дүнд хүрсэн, 24 зорилт эрчимжүүлэх шаардлагатай, 25 зорилт хэрэгжээгүй бөгөөд гэрээний хэрэгжилт 85,9% хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		793,358.8	749,699.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	131,013.4	247,552.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	522,757.6	341,510.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	139,587.8	160,636.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,606,780.4	2,125,989.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,606,780.4	2,125,989.2
39200	Биет хөрөнгө		1,522,199.0	2,022,540.4
39300	Биет бус хөрөнгө	13	84,581.4	103,448.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,400,139.2	2,875,688.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,593.1	8,613.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,593.1	8,613.7
41300	Өглөг	17а, 17б	5,593.1	8,613.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,394,546.1	2,867,074.5
51	Засгийн газрын хувь оролцоо		2,394,546.1	2,867,074.5
51200	Хуримтлагдсан үр дүн		1,773,251.5	2,245,779.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,400,139.2	2,875,688.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,521,911.9	2,345,635.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		300,509.9	487,739.8
110	Орлогын албан татвар		140,586.8	293,056.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		144,586.8	293,056.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(4,000.0)	-
113	Хөрөнгийн албан татвар		30,340.1	48,149.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж		129,583.0	146,533.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	593,937.8	379,688.4
120	Нийтлэг татварын бус орлого		435,848.0	379,688.4
122	Тусламжийн орлого		158,089.8	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,627,464.2	1,478,207.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,262,734.8	1,867,450.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,816,021.4	1,388,858.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,463,007.9	1,339,048.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		450,305.7	620,560.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт		54,833.6	73,022.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		53,360.0	244,031.0
2104	Хангамж, бараа материалын зардал		50,853.9	38,013.8
2105	Норматив зардал		36,574.9	64,451.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		-	30,003.0
2107	Томилот, зочны зардал		5,274.0	8,826.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төл		5,266.3	4,995.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		806,539.6	255,144.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,353,013.6	49,810.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		446,713.4	478,591.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		259,177.1	478,184.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		10,304.8	5,656.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-		248,872.2	472,528.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруул	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		3,210,965.7	2,105,584.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		300,509.9	490,032.9
110	Орлогын албан татвар		140,586.8	293,056.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		144,586.8	293,056.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		(4,000.0)	-
113	Хөрөнгийн албан татвар		30,340.1	50,442.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		129,583.0	146,533.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		812.6	6,081.1
1181	Газрын төлбөр		37,078.5	76,613.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		91,691.9	63,839.3
1183	Бусад татвар		-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		287,325.9	183,261.5
120	Нийтлэг татварын бус орлого		129,236.1	183,261.5
122	Тусламжийн орлого		158,089.8	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,623,129.9	1,432,290.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,631,391.1	1,300,277.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,631,391.1	1,300,277.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,278,377.6	1,251,470.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		450,510.5	621,495.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		54,549.1	71,890.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		52,631.6	365,478.4
2104	Хангамж, бараа материалын зардал		22,864.5	34,617.6
2105	Норматив зардал		1,000.0	999.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,300.0	35,693.0
2107	Томилолт, зочны зардал		5,274.0	8,934.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х		7,062.3	5,650.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		682,185.6	106,711.5
211	ХҮҮ		-	-
212	ТАТААС		-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,353,013.6	48,807.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I		579,574.5	805,307.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		728,901.2	687,647.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		728,901.2	687,647.3
2200	Дотоод эх үүсвэрээр		728,901.2	687,647.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (V		(728,901.2)	(687,647.3)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН Г		(91,775.0)	(1,121.5)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		91,775.0	1,121.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		(241,101.6)	116,538.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		372,115.0	131,013.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3а, 3б	131,013.4	247,552.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоон нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,100,079.8	-	2,100,079.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөл	1,155.0	-	1,155.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,101,234.8	-	2,101,234.8

4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бу	(1,155.0)	-	(1,155.0)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	45,594.0	-	45,594.0
9	Тайлант үеийн үр дүн	248,872.2	-	248,872.2
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,394,546.1	-	2,394,546.1
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,394,546.1	-	2,394,546.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,394,546.1	-	2,394,546.1
19	Тайлант үеийн үр дүн	472,528.4	-	472,528.4
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,867,074.5	-	2,867,074.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,110,944.6	1,720,007.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,316,183.0	1,157,979.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,306,875.0	1,148,681.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607,205.2	562,060.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,900.7	65,237.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	433,944.9	365,478.4
2104	Хангамж, бараа материалын зардал	30,756.2	28,516.7
2105	Норматив зардал	1,000.0	999.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,500.0	53,079.9
2107	Томилолт, зочны зардал	9,852.0	8,424.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	13,666.0	13,503.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,050.0	51,382.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,308.0	9,297.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,308.0	9,297.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	692,821.7	560,906.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,939.9	1,121.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,110,944.6	1,840,128.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	357,881.7	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,428,703.0	1,745,537.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	324,359.9	94,590.8
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,709.7	238,686.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,709.7	231,170.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	347,577.9	189,213.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,980.0	59,435.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,279.3	6,653.6
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,101.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
2107	Томилолт, зочны зардал	-	510.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй	0.3	1,147.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	309.0	115,366.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,131.8	41,957.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	23,740.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,131.8	18,216.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	7,516.3
2200	Дотоод эх үүсвэрээр	-	7,516.3
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	370,709.7	232,738.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	370,709.7	232,738.0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратегийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, мал аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант онд Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга дараах хөрөнгө оруулалтын болон бусад ажлуудыг зохион байгуулан хийсэн байна. Үүнд:

1. Айл өрх бүрд нарны эрчим хүчээр цэнэглэдэг гэрэлтүүлэгтэй болгосон.
2. ЕБС, Хүүхдийн цэцэрлэгийн дотор сангийн их засвар хийгдсэн.
3. Галуут, Байдлаг багт шинээр гүүр тавигдсан.
4. Хогийн цэгийг шинэчлэн байгуулсан байна.

Аймгийн Засаг дарга болон Сумын засаг дарга нарын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ нь 2024 онд нийт 11 зорилт, 105 хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ дэвшүүлэн ажилласнаас 44 зорилтын хэрэгжилт үр дүнтэй, 12 зорилт тодорхой үр дүнд хүрсэн, 24 зорилт эрчимжүүлэх шаардлагатай, 25 зорилт хэрэгжээгүй бөгөөд гэрээний хэрэгжилт 85,9 % хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна гэж дүгнэлээ.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн ТЕЗ-ийн бөгөөд Засаг даргын 2021 онд “Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байгаа боловч

Сангийн сайдын нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой шинээр гарсан заавар журамтай холбогдуулан өөрчлөлт шинэчлэлийг хийгээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баяндэлгэр сум нь Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 475,549.0 мянган төгрөгөөр буюу 19,8 хувиар өссөн байна. Энэ дээр дурдсан орон нутгийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт зэрэг нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
			2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		793,358.8	749,699.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	131,013.4	247,552.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	522,757.6	341,510.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	139,587.8	160,636.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,606,780.4	2,125,989.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,606,780.4	2,125,989.2
39200	Биет хөрөнгө		1,522,199.0	2,022,540.4
39300	Биет бус хөрөнгө	13	84,581.4	103,448.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,400,139.2	2,875,688.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,593.1	8,613.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,593.1	8,613.7
41300	Өглөг	17а, 17б	5,593.1	8,613.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,394,546.1	2,867,074.5
51	Засгийн газрын хувь оролцоо		2,394,546.1	2,867,074.5
51100	Засгийн газрын оруулсан капитал		195,964.7	195,964.7
51200	Хуримтлагдсан үр дүн		1,773,251.5	2,245,779.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		425,329.9	425,329.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН		2,400,139.2	2,875,688.2

Эх сурвалж: Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 247,551.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 116,538.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сан 108,051.7 мянган төгрөг, ОНХС 14,755.1 мянган төгрөг, Орон нутгийн ерөнхий орлого 9,583.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авллага дансны үлдэгдэл 345,226.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 177,531.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 94,478.2 мянган төгрөг, ЗДТГ-ын засварын ажил 92,583.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 160,636.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,048.8 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ 8,545.4 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 11,213.5 мянган төгрөг, ИТХ 1,290.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,125,989.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 519,208.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгө 519,798.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Өглөг дансны үлдэгдэл 8,613.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,020.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ОНХО малын тоо толгойн албан татвар 2,293.2 мянган төгрөг, нөхөн сэргээх барьцаа санд байгууллагад өгөх 500.0 мянган төгрөг, ОНХС 250.0 мянган төгрөг, ЗДТГ 217.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,866,255.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 471,709.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 471,709.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 247,551.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 116,538.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+) Бууралт (-)
			Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	131,013.4	247,551.9	116,538.5
Төгрөг	131,013.4	247,551.9	116,538.5
Төрийн сангийн харилцах	119,810.8	243,557.8	123,747.0
Арилжааны банк дахь харилцах	11,202.6	3,994.1	(7,208.5)
ДҮН	131,013.4	247,551.9	116,538.5

Эх сурвалж: Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 247,551.9 мянган төгрөгийн 45,5 хувь буюу 110,747.8 мянган төгрөгийг ХХС-ийн, 24,6 хувь буюу 59,824.5 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 23,5 хувь буюу 57,300.3 мянган төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлогын, 4,6 хувь буюу 11,150.0 мянган төгрөгийг БНСБС, 1,9 хувь буюу 4,535.3 мянган төгрөгийг Орон нутгийн нэмэлтийн татан төвлөрүүлэлтийн дансны үлдэгдэл тус тус эзэлж байна. Арилжааны банк дахь харилцах дансны 3,994.1 мянган төгрөгийг Эмийн эргэлтийн сангийн 3,994.1 мянган төгрөгийн үлдэгдэл эзэлж байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 247,551.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 116,538.5 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлогын данс 9,583.0 мянган төгрөг, ОНХС 14,755.1 мянган төгрөг, ХХС-гийн эргэн төлөлт 108,051.7 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

- ИТХ, ЗДТГ-ын төрийн захиргааны албан хаагчдад хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшуулал 23,739.9 мянган төгрөг олгосноос ХХОАТ-ыг суутган тооцож аваагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд хүчингүй тогтоолын заалтаар урамшууллын зардал 1,700,0 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичигдсэн.
- ЗДТГ-ын техник тоног төхөөрөмж авах зардалд 40,000.0 мянган төгрөг батлагдсан байтал компьютер, принтер гэх мэт тоног төхөөрөмж 62,500.0 мянган төгрөгөөр тендергүйгээр худалдан авалт хийсэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага бичсэн.
- ЗДТГ-ын сумын төсвийн хөрөнгө оруулалтаар дээрх тогтоолын 3 дугаар хавсралтаар "2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт /шилжих үлдэгдэл" гэж баталсан боловч нэг ч барилга байгууламж хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тусгаагдаагүй урсгал зардал, техник тоног төхөөрөмжийн жагсаалт баталжээ. Мөн түүнчлэн "ЗДТГ-ын хатуу эдлэл" гэсэн нэрээр яг ямар зориулалттай нь тодорхойгүй 40,000.0 мянган төгрөг, нэр зааж заагдаагүй зардал 15,000.0 мянган төгрөг, хувьд гэсэн нэрээр 24,700.0 мянган төгрөг баталсан нь нэр томъёоны хувьд болон, агуулгын хувьд тодорхойгүй байсан зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.
- Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн Засаг даргын орлогчид 11,220.0 мянган төгрөгийн тэтгэмжийг хууль тогтоомжид заагаагүй байхад олгосон зөрчилд төлбөрийн акт бичигдсэн.
- Дуудлага худалдааны орлогыг дутуу төвлөрүүлсэн, орон нутгийн орлогоос илүү санхүүжүүлснийг төвлөрүүлээгүй зөрчилд 1,756.4 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигдсэн.
- Эргэлтийн эмийн санд Эрүүл мэндийн төвийн даргын шийдвэргүй 3,500.0 мянган төгрөгийн эд хогшил, засварын ажлын материал авсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

8. Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайлан 7,241.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 345,226.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 177,530.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Дансны авлага	980.9	763.2	(217.7)
Байгууллагаас авах авлага	136,649.2	46,358.5	(90,290.7)
Хувь хүмүүсээс авах авлага	385,127.4	298,104.9	(87,022.5)
ДҮН	522,757.5	345,226.6	(177,530.9)

Эх сурвалж: Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 345,226.6 мянган төгрөгийн 86,4 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 13,4 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Бусад авлагын 344,463.4 мянган төгрөгийн 86,5 хувь буюу 298,104.9 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн, 13,5 хувь буюу 46,358.5 мянган төгрөгийн авлага нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлагын үлдэгдэл 35,606.6 мянган төгрөг, ЗДТГ-ын 10,751.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Авлага дансны үлдэгдэл 345,226.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 177,531.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Орон нутгийн хөгжлийн сан 2,293.2 мянган төгрөг, Эргэлтийн эмийн сан 7,255.7 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 94,478.2 мянган төгрөг, ЗДТГ-ын байгууллагаас авах авлага 92,583.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт

1. ХХС-ийн нийт 34 зээлдэгчийн 19 буюу 151,052.3 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл хугацаа хэтэрсэн байгаа нь чанаргүй зээлийн хэмжээ нийт хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байна гэсэн шаардлагыг зөрчсөн тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага тогтоов.
2. ХХС нь тайлант онд зээлийн эргэн төлөлт нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн байхаас 25,232.9 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.
3. Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн сангаас 88 зээлдэгчийн 743,721.1 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл нь Санхүүгийн тайлангаарх 34 зээлдэгчийн 288,664.5 мянган төгрөгийн үлдэгдлээс 455,056.5 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.
4. Орон нутгийн орлогын нэгдсэн дансанд төвлөрсөн малын тоо толгойн албан татварын орлогыг ОНХС-д дутуу төвлөрүүлснийг 2,543.2 мянган төгрөгөөр авлага дансанд тусган зөрчлийг залруулсан.
5. Баг хөгжлийг дэмжих сангаас Төрийн албан хаагчдын авсан зээлийн үлдэгдэл 3,306.4 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй, Мянганы сорилын сангийн зээлийн хугацааг хэтэрсэн үлдэгдлийг Монгол банкны мэдээллийн санд оруулаагүй 15,040.0 мянган төгрөгийг төлүүлэн санд нь төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичигдсэн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 160,636.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,048.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+)
			Бууралт (-)
Түүхий эд материал	17,131.0	28,344.4	11,213.4
Эм боох материал	17,131.0	28,344.4	11,213.4
Хангамжийн материал	122,456.9	132,292.2	9,835.4
Бичиг хэргийн материал	927.1	803.3	(123.8)
Аж ахуйн материал	38,276.6	44,033.0	5,756.4
Сэлбэг хэрэгсэл			-
Түлш, шатах тослох материал	1,302.6	4,783.3	3,480.7
Барилгын засварын материал	1,787.0	1,787.0	-
Хүнсний материал	240.9	240.9	-
Бусад хангамжийн материал	57,614.0	69,954.8	12,340.8
Биологийн хөрөнгө	-	5,600.0	5,600.0
Мал амьтад	22,308.7	5,090.0	(17,218.7)
ДҮН	139,587.8	160,636.6	21,048.7

Эх сурвалж: Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 160,636.6 мянган төгрөгийн 80,9 хувийг ЗДТГ, 17,6 хувийг Эмийн эргэлтийн сан, 1,5 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 160,636.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,048.7 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ 8,545.4 мянган төгрөг, ИТХ 1,290.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 11,213.4 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансанд оны эхний үлдэгдэл 139,587.8 мянган төгрөг байсан бол 187,128.9 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 59,037.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 246,166.4 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж бүртгэсэн ба 207,908.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, 17,208.7 мянган төгрөг бараа материал шилжүүлэн, 160,636.6 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

1. Эргэлтийн эмийн сангийн бараа материалын тооллогоор хугацаа дууссан эмийг устгах жагсаалт нь актлах үнийн дүнгээс 2,358.7 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага тогтоов.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,125,989.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 519,208.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+)
			Бууралт (-)
Биет хөрөнгө	1,522,199.0	2,022,540.4	500,341.4
Барилга, байгууламж, орон сууц	951,776.0	1,176,221.5	224,445.5
Авто-тээврийн хэрэгсэл	108,342.0	106,851.4	(1,490.7)
Машин тоног төхөөрөмж	156,165.2	166,790.2	10,625.0
Тавилга,аж ахуйн эд хогшил	3,411.1	55,867.2	52,456.1
Зам гүүрний барилга		40,000.0	40,000.0
Бусад үндсэн хөрөнгө	302,504.7	476,810.2	174,305.5
Биет бус хөрөнгө	84,581.4	103,448.8	18,867.4
Программ хангамж	891.4	7,891.4	7,000.0
Бусад биет бус хөрөнгө	83,690.0	95,557.4	11,867.4
ДҮН	1,606,780.4	2,125,989.3	519,208.9

Эх сурвалж: Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,7 хувь буюу 2,119,145.3 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,3 хувь буюу 6,821.9 мянган төгрөгийг Эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,125,989.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 519,208.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ЗДТГ 519,798.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үнээрээ оны эхний үлдэгдэл 2,408,475.6 мянган төгрөг, тайлант онд 250,266.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 312,268.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 562,534.6 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж бүртгэсэн ба 48,858.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж 2,920,889.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байна.

Аудитын илрүүлэлт:

1. ЗДТГ нь Ухаалаг засаглал НҮТББ руу гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилт оруулах цахим программ лицензийн төлбөрт 7,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, хөрөнгийг орлого аваагүй байсныг залруулсан.
2. Мөнгөн гүйлгээний тайлангаарх биет болон биет бус хөрөнгө авсан дүн үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийн дүнгээс 216,660.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.
3. ЗДТГ-ын газар эзэмших эрхийн 6 газрын суурь үнийг зөрүүтэй бүртгэсэн, 76 мкв газар эзэмших эрхгүй газрыг 530,6 мянган төгрөгөөр илүү бүртгэснийг залруулсан байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 19,979.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,506.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,708.0	4,279.2	571.2
Байгууллагад төлөх өглөг	1,885.1	4,084.5	2,199.4
Хувь хүмүүст төлөх өглөг		250.0	250.0
ДҮН	5,593.1	8,613.7	3,020.6

Эх сурвалж: Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны жилийн эцсийн үлдэгдлийн 47,6 хувь буюу 4,100.0 мянган төгрөгийг БНСБС, 26,6 хувь буюу 2,293.2 мянган төгрөгийг ОНЕО, 20,8 хувь буюу 1,791.4 мянган төгрөгийг ЗДТГ, 5,0 хувь буюу 429.2 мянган төгрөгийг ОНХС, ИТХ-ын өглөгийн үлдэгдэл эзэлж байна.

Өглөг дансны үлдэгдэл 8,613.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,020.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь ОНЕО малын тоо толгойн албан татвар 2,293.2 мянган төгрөг, Байгалийн нөхөн сэргээх барьцаа сангийн байгууллагад өгөх 500.0 мянган төгрөг, ОНХС 250.0 мянган төгрөг, ЗДТГ 217.7 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн алдаа зөрчилгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,867,074.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 472,528.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	195,964.7	195,964.7	-
Хуримтлагдсан үр дүн	1,773,251.5	2,244,960.8	472,528.4
Өмнөх үеийн үр дүн	1,524,379.2	1,773,251.5	-

Тайлант үеийн үр дүн	248,872.3	472,528.4	472,528.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	425,329.9	425,329.9	-
ДҮН	2,394,546.0	2,867,074.5	472,528.4

Эх сурвалж: Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 2,867,074.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 472,528.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 472,528.4 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг /сангууд орохгүй/ орон нутгийн төсвөөс 1,286,122.4 мянган төгрөг, нийт зарлагыг 1,286,1226.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 681,922.7 мянган төгрөгөөр нэмж, сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 39 дүгээр тогтоолоор нийт зардал 1,968,045.1 мянган төгрөгөөр, үүнээс урсгал зардлыг 1,324,602.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 643,443.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2024 оны 4 дүгээр сараас эхлэн төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20 хувь, бусад төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10 хувиар нэмэгдүүлэх, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д “Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно” гэж нэмэлт өөрчлөлтөөр орон нутгийн нэмэгдлийг хөдөөгийн суманд үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгох, Төрийн албаны тухай хуульд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр орсон өөрчлөлтөөр орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор заасны дагуу шаардагдах зардлыг тус тус нэмснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 142,899.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн сумын ИТХ-ын 2024 оны 10 дүгээр сарын 25-ны өдрийн 26 тоот тогтоолоор 2,110,944.6 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Энэ нь урсгал зардлыг 1,316,183.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 692,821.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт дүнгээр 142,899.5 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр татварын болон татварын бус орлогоор 584,537.8 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 844,165.2 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдэл 222,420.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын 101,939.9 мянган төгрөгийн нийт 2,110,944.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 459,223.3 мянган төгрөгийн санхүүжилт, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 844,165.2 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 381,351.3 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 94,590.8 мянган

төгрөгийн нийт 1,779,330.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 331,614.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн батлагдсан төлөвлөгөөгөөр 101,939.9 мянган төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 94,590.84 мянган төгрөг бүрдүүлж 7,349.1 мянган төгрөгийн эх үүсвэр дутуу бүрдүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг сумын ИТХ-ын хуралдаанаас 584,537.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 493,234.9 мянган төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 91,302.9 мянган төгрөгөөр буюу 15,6%-иар тасалсан ба нэр төрлөөрөө 7 нэр төрөлд 128,939.7 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнийг задалбал: малын тоо толгойн албан татвар 77,706.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогын албан татвар 21,515.3 мянган төгрөг, цалингийн ашиг 14,571.7 мянган төгрөг, ойн төлбөр 7,640.5 мянган төгрөг, хүү торгуулийн орлого 6,088.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамж 1,417.4 мянган төгрөг, агнуурын төлбөр 50,566.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь нөлөөлсөн байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын 2024 онд зарцуулах зарлагын тодотгон батлагдсан төлөвлөгөө 2,110,944.6 мянган төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 1,670,007.7 мянган төгрөг буюу 440,936.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, гүйцэтгэл 79,11 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 55,808.5 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 68,466.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 2,239.5 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардал 3,420.1 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтын зардал 1,428.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 162.2 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардал 26,667.5 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 10,200.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 181,915.0 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 101,939.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны б	133,786.2	131,382.8	2,403.4	98.2
2	70106 –Орон нутгийн гүйцэтгэх засаглалы	976,629.4	852,009.2	124,620.2	87.2
3	70106 – Хоршоо хөгжүүлэх сан	101,939.9	1,121.5	100,818.4	1.1
4	71602 - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	56,220.0	50,203.5	6,016.5	89.3
5	71702 –Соёлын үйлчилгээ	154,754.8	122,790.4	31,964.4	79.3
6	71801- Сургуулийн өмнөх боловсрол	28,481.5	25,476.3	3,005.2	89.4
7	71802 Ерөнхий боловсролын сургууль	121,431.1	120,177.5	1,253.6	99.0
8	70106- Орон нутгийн хөгжлийн сан	537,701.7	366,846.2	170,855.5	68.2
	Нийт дүн	2,110,944.6	1,670,007.4	440,937.2	79.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 240,035.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 220,469.5 мянган төгрөг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 19,565.4 мянган төгрөгийг аймаг болон орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 240,035.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, цалин нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардал 66,088.8 мянган төгрөг, тээвэр шатахууны зардал 6,101.0 мянган төгрөг, томилолтын зардал 510.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 1,147.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 115,366.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан мөнгөн урамшуулал 23,740.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 7,516.3 мянган төгрөг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 19,565.4 мянган төгрөгийг аймаг болон орон нутгийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/		
					Зарцуулах төсөв	Зарцуулсан	Хувь
1	70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2024.01.01 2024.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, хороо ажлын хэсгүүдэд үзүүлэх үйлчилгээ	Сумын ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангаж, жилд 5 удаа хуралдсан байна. БИНХ-ыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна.	131,786.3	129,383.4	98%
		2024.01.01 2024.12.31	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны нэгдсэн хөтөлбөр дагуу явагдаж үр дүнг бодитой тооцно.	ГХУСДЗ-үүд ажлын төлөвлөгөө гарган ИТХ-ын хуралдаанд танилцуулан ГХУ чиглэлээр эргүүл шалгалтыг 7 удаа хийж 12 р сарын байдлаар малын хулгайн гэмт хэрэг 2, бусад 1 нийт 3 хэрэг бүртгэгдэж, үүнээс 75%-ийг шийдвэрлэсэн байна.	2,000.0	1,999.0	100%
2	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2024.01.01 2024.12.31	Сумын хөгжлийн хөтөлбөр, ЗДМХ, НЭЗҮ чиглэлийг хэрэгжүүлж ажиллана.	Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр биелэлт-90.2%-тай дүгнэгдэж сумын ИТХ-ын хуралдаанаар "Хангалттай" дүгнэгдсэн.	906,579.4	809,026.6	89%
		2024.01.01 2024.12.31	Орон нутгийн нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ	Онцгой байдлын хүрээнд /малын гоц халдварт цэцэг өвчин / гарсан Тээвэр шатахуун, хоол хүнс болон бусад зардалд шийдвэрлэсэн байна.	5,000.0	1,150.0	23%
		2024.01.01 2024.12.31	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалах тээвэр шатахуун, нөхөн сэргээлт, ойжуулалт, хогийн савын хангалт зэрэг ажлууд бүрэн хийгдсэн.	65,050.0	41,832.6	64%
		2024.01.01 2024.12.31	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /ОНХС/	ОНХС-аар 8 ажил төлөвлөгдөж 6 ажил бүрэн хийгдэж 2 ажил оролцогчгүйгээс хэрэгжээгүй Хийгдэх ажил 81.8% хэрэгжсэн. Тендерийн болон хийгдээгүй ажлын хэмнэлт үүссэн 59,824.5 мянга төгрөг байна.	537,701.7	366,846.2	68%
	71802-Ерөнхий боловсролын сургууль	2024.01.01 2024.12.31	ЕБС-ийн тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	Тус байгууллагын халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг санхүүжүүлж хэмнэлтийг төвлөрүүлсэн.	121,431.0	120,177.	99%
	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2024.01.01 2024.12.31	СӨБ-ын тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	Тус байгууллагын халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг санхүүжүүлж хэмнэлтийг төвлөрүүлсэн.	28,481.5	25,476.3	89%
	71602-Эрүүл мэндийн төв	2024.01.01 2024.12.31	ЭМТ-ийн тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	Тус байгууллагын халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг санхүүжүүлж хэмнэлтийг төвлөрүүлсэн.	56,220.0	50,203.5	89%
	71702-Соёлын үйлчилгээ	2024.01.01 2024.12.31	Соёлын төвийн тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	Тус байгууллагын халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг санхүүжүүлж хэмнэлтийг төвлөрүүлсэн.	154,754.8	122,790.	79%
3	70106-ХХС	2024.01.01 2024.12.31	ХХС журмыг дагаж мөрдөх.	ХХС-аас зээл олгоогүй.	101,939.9	1,121.5	1%

Нийт дүн					2,110,944	1,670,007	79%

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд хөрөнгө оруулалтын төлөвлөгдсөн төсөл арга хэмжээнээс 2 буюу 170,855.5 мянган төгрөгийг бараа, ажил, үйлчилгээ оролцогчгүй хэрэгжээгүй, Хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэр бүрэн бүрдсэн ч зээл олгоогүй нь нөлөөлсөн байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А/05 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталжээ. Урсгал төсвөөс санхүүжих орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 23 арга хэмжээнд 451,973.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаар гүйцэтгэх 8 арга хэмжээнд 486,761.3 мянган төгрөг, нийт 938,734.8 мянган төгрөгийг баталсан байна.

Худалдан авах ажиллагааны тайлангаар 31 бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар 938,816.5 мянган төгрөгөөр баталснаас 2 бараа, ажил, үйлчилгээ оролцогч байгууллага байхгүйн улмаас хийгдээгүй байна. Бусад 769,597.9 мянган төгрөгийн 29 бараа, ажил, үйлчилгээг харьцуулалтын аргаар 8, шууд худалдан авалтаар 21 ажлыг худалдан авалтын гэрээг байгуулан ажилласан байна.

Сумын ОНХС-ийн эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг 357,881.7 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 114,000.0 мянган төгрөг, оны эхний /2023 оны татвар/ үлдэгдэл 14,961.3 мянган төгрөг нийт 486,843.0 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр баталсан, гүйцэтгэлээр 476,670.7 мянган төгрөг төвлөрсөн байна. Тус эх үүсвэрээр тайлант онд 11 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас 9 төсөл арга хэмжээ хэрэгжиж 416,846.2 мянган төгрөг зарцуулжээ.

Сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар орон нутгийн орлогын нэгдсэн дансанд төвлөрсөн малын тоо толгойн албан татварын 1,947.0 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлснийг авлагаар тусгаагүй зөрчлийг арилгуулж, санхүүгийн тайланд залруулга хийсэн.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/15 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2024 оны батлагдсан төсвийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2024 оны батлагдсан төсвийн нийт орлогыг 3,521,911.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 52,828.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70,0 хувиар буюу 36,980.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон хуульд заагдаагүй тэтгэмж олгохоор төсвийн тодотголд оруулан ИТХ-аар шийдвэрлүүлэн ЗД-ын орлогч-д 11,220.0 мянган төгрөгийн зардал гаргасан, дансны авлага ОНХС-ийн 31,890.4 мянган төгрөгийн авлага оны эхнээс буураагүй үлдэгдэлтэй, өглөг 3,020.6 мянган төгрөгөөр өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 181 мэдээлэл байршуулахаас Шилэн дансанд байршуулбал зохих худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн

жагсаалт, гүйцэтгэл, санхүүгийн тайланг /хагас жил тутамд/ хуульд заасан хугацаанд мэдээлээгүй, мэдээллийг ойлгомжгүй, дутуу, мэдээллүүдийг шилэн дансанд оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн зэрэг зөрчил гаргасан байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 33,8 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилт 88,7 хувь байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын эхний хагас жилийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар “дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт авч хариуцлага тооцох албан шаардлага өгснийг 100,0% хэрэгжүүлэн Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/271 дүгээр албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Ха	Өмнөх аудитын шийдвэрлэлт			/мянган төгрөгөөр/ Биелэлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100,0
ДҮН	1	-	1	-	100,0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баяндэлгэр сумын орон нутгийн татварын орлогын ногдуулалт, төлөвлөлт, бүрдүүлэлтийн байдал, газрын эрх шилжүүлсэн татварын орлого төвлөрүүлсэн байдал, орон нутгийн хөгжлийн санд гүйцэтгэлийн аудит хийгдэх тул дараагийн аудитаар анхаарах асуудал гэж авч үзлээ. Мөн нягтлан бодох бүртгэлийн заавар журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан, баталж, мөрдүүлэн ажилласан эсэхийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 538792,7 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 538,792.7 мянган төгрөгийн алдааг залруулсан.

1. Орлогын гүйцэтгэл тодруулга тайланд ХХС-ийн эргэн төлөлтийн орлого 94,590.8 мянган төгрөг, ОНХС-ийн 347,351.3 мянган төгрөгийн санхүүжилтийн орлогыг тайлагнаагүй нэгтгэсэн байна.
2. Авлагын тодруулга тайланд тооцоо нийлсэн актгүй 47,121.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд: ОНХС 35,606.6 мянган төгрөг, ЗДТГ 11,476.9 мянган төгрөг, ИТХ 38.2 мянган төгрөгийг нэгтгэсэн байна.
3. Өглөгийн тодруулга тайланд тооцоо нийлсэн актгүй 8,613.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд: ОНХО 2,293.2 мянган төгрөг, ОНХС 250.0 мянган төгрөг, ЗДТГ 1,791.4 мянган төгрөг, ИТХ 179.2 мянган төгрөгийг нэгтгэсэн байна.
4. Үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд хоорондын тооцоо үүсгэсэн 28,014.3 мянган төгрөгийн ЭМТ, ЗДТГ, ИТХ, СТ, ЕБС, СӨБ татан төвлөрүүлэлтийн хоорондын тооцоог хаагаагүй байна.
5. Мөнгөн гүйлгээний тайлан дахь төвлөрүүлэх шилжүүлэг 15,868.1 мянган төгрөг төсвийн тохируулгын тайлан 20,717.3 мянган төгрөг хоорондоо 4,849.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.
6. Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансны үлдэгдэл 4,535.3 мянган төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлогын тайлангийн үлдэгдлээр санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.
7. Нэгтгэсэн тайланд 2022 оны жилийн эцэст Гарден сити ХХК-аас авах 3,716.4 мянган төгрөгөөр тайлагнасан бөгөөд 2023 онд тус компаниас илүү авсан 3,716.4 мянган төгрөгийг төлснийг дансны авлагаар хаагаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 4,004,375.3 мянган төгрөгийн зөрчлөөс 173,407.8 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 120,579.1 мянган төгрөгөөр их тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,004,375.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 173,407.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,830,952.3 мянган төгрөгийн хариуцлага тооцуулах албан шаардлага, алдаа зөрчлийн давтан гаргахгүй байх 15.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй болно.

5.2 Албан шаардлага

Татварын орлого нийт дүнгээрээ 91,302.9 мянган төгрөг, нэр төрлөөрөө 7 нэр төрөлд 173,407.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнийг задалбал малын тоо толгойн албан татвар 77,706.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогын албан татвар 21,515.3 мянган төгрөг, цалингийн ашиг 14,571.7 мянган төгрөг, ойн төлбөр 7,640.5 мянган төгрөг, хүү торгууль 6,088.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамж 1,417.4 мянган төгрөг, агнуурын төлбөр 50,566.0 мянган төгрөг тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 23 дугаар зүйлийн 23.1-д “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23.8-д “Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага тогтоов.

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг ойлгомжгүй, дутуу мэдээллүүдийг шилэн дансанд оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн, Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 33,8 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.2.4-д “хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, төр хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Татварын орлогын мэдээнээс харахад 3 нэр төрлийн орлого 35,873.3 мянган төгрөгөөр дутуу, 4 нэр төрлийн орлого 35,888.5 мянган төгрөгөөр илүү нийт дүнгээр 15.2 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 24.3-д “Татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж,

төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогын мэдээг үнэн зөв мэдээлж буй эсэхэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах

2. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт:

Дотоод хяналт шалгалтыг томилсон шийдвэр, ажлын төлөвлөгөөгүй дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5-д "Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах шийдвэрийг гарган баталгаажуулан, хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж, шалгалтын зорилго, хамрах хүрээ, шалгалтын аргачлал, хугацаа зэргийг тодорхойлж, хяналт шалгалтын удирдамжийг боловсруулж, шалгалт хийх багийн гишүүдэд танилцуулж, шалгалтын явцад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, шалгалтын үр дүнг тайлагнаж, илэрсэн зөрчил, дутагдлыг засах арга хэмжээний талаар зөвлөмж өгч ажиллах

3. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан заавар журамтай холбогдуулан шинэчлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, батлуулах, мөн хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулж, санхүүгийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажил зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	7	538,792.7			7	538,792.7	7	538,792.7
Засаг даргын Тамгын газар	3	224,191.5	1	7,000.0	2	217,191.5	3	224,191.5
Орон нутгийн хөгжлийн сан	1	2,543.2	1	2,543.2			1	2,543.2
Эргэлтийн эмийн сан	1	7,241.9			1	7,241.9	1	7,241.9
Дүн	12	772,769.3	2	9,543.2	10	763,226.1	12	772,769.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	дүн
Засаг дарга	4	173,423.0			1	173,407.8	3	15.2		
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2	2,575.5	2	2,575.5						
Засаг даргын Тамгын газар	5	233,614.0	3	14,474.9	1	62,539.1	1	156,600.0		
Хоршоо хөгжүүлэх сан	3	136,345.0			1	111,111.1	1	25,232.9	1	455,056.6
Эргэлтийн эмийн сан	1	2,358.7			1	2,358.7				
Дүн	15	548,316.1	5	17,050.4	4	349,416.7	5	181,848.1	1	455,057

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	3,830,952.3			1	3,830,952.3		
Орон нутгийн хөгжлийн сан	1	1,947,045.2					1	1,947,045.2
Хоршоо хөгжүүлэх сан	3	417,758.7	2	18,346.4			1	399,412.3
Дүн	4	2,364,803.9					2	2,346,457.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	4	2,364,803.9	-	-	-	-	2	2,346,457.5

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Өөрчлөлттэй		
1	санал дүгнэлт гаргах	Түүвэрт хамрагдах	Аудит хийгээгүй	Хязгаар лалтай		Сөрөг	Дүгнэлт өгөхөс татгалзсан	
Төсвийн шууд захирагч	2	3	4	5	6	7	8	9
Орон нутгийн тусгай сан	2	1	1			1		
Төсвийн төвлөрүүлэн захирагч	4		4					
Дүн	1	1				1		
Дүн	7	2	5	-	-	2	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

АУДИТЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ЭРГЭЦИЙН ХУУДАС

1. Ерөнхий мэдээлэл

Аудитын нэр	Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга
Аудитын код:	ТӨА-2025/021/НА-СТА-ТТЗ
Баримт бичгийн төрөл	Аудитын тайлан

Хугацаа заасан эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй	Өгөх ёстой огноо: 2025.02.25
Аудитыг гүйцэтгэсэн багийн гишүүд	Аудитын менежер: /О.Амаржаргал/ Ахлах аудитор: /Ц.Саранчимэг/	

2. Гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтын эргэцийн хүснэгт

Огноо		Шийдвэр		Чанарын хяналтаар өгсөн санал, зөвлөмжийн товч утга	Чанарыг хянан удирдсан албан хаагч		
Хүлээн авсан	Буцааж өгсөн	Засвар, санал, зөвлөмж байхгүй дараагийн шатанд шилжүүлэх	Засвар, санал, зөвлөмжийг тусгаж дахин хянуулах		Албан тушаал	Нэр	Гарын үсэг
2025.03.25	2025.03.25	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Санхүүгийн тайлангийн үгнүүдийг хүснэгтдээ багтаах, Тоонуудыг шараар яагаад тэмдэглэсэн бэ?, ОНХС, хөрөнгө оруулалтын зөрчил байхгүй юу?	Аудитын менежер	О.Амаржаргал	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				

Аудитын төлөвлөгөө /тайлан/-г баталгаажуулахыг зөвшөөрсөн:

Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Хишигжаргал

2025 оны 03 сарын 25-ны өдөр